

ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ЛИЦЕНЗ ХҮСЭХ ЗААВАР

1.Өргөдөл гаргахын өмнө Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газрын асуудал хариуцсан мэргэжилтнээс өөрийн байгууллагын цахим системд нэвтрэх кодыг авна.

2. Цахим системд дараах веб хаягаар орж, лиценз хүсэх өргөдөл, импортын тайланг ирүүлнэ. <http://www.mohs.mn/licemed/>

3.Цахим хэлбэрээр өргөдөл гаргах

3.1. “login”-д орж

- Username: u..(кодоо бичнэ)
- Password: (кодоо бичнэ)...

3.2. “Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох лиценз хүсэх өргөдөл үүсгэх” гэсэн хэсэгт нэвтэрнэ.

3.3. Өргөдөл гаргагчийн нэрийг оруулаад, хилийн боомтыг сонгоно.

3.4. Эмийн бүртгэлийн жагсаалтаас эмээ сонгож, тоо ширхэгийг оруулна.

3.5. Эмнэлгийн хэрэгсэлийн тоо ширхэгийг бичиж оруулна.

3.6. Дараагийн нэр, төрлийг “шинэ зүйлийг нэмэх” гэж оруулна.

“Явуулах” гэдэг цонхыг дарж өргөдлийг илгээнэ.

4. Хандив тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийн импортын лиценз хүсэх өргөдөл өгөх бол “Хандив тусламжийн эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох лиценз хүсэх өргөдөл үүсгэх” гэж ороод бүртгэлгүй зүйлийг сонгож, дээрх дарааллын дагуу мэдээллийг оруулж, өргөдлийг илгээнэ.

5. Цахим хэлбэрээр импортын тайлан ирүүлэх

5.1. Энэ зааврын 2 дугаар заалтад байгаа веб хаягаар орж кодоо хийнэ.

5.2. “Өргөдлүүдийг харах” гэсэн цонхыг сонгоно.

5.3. “Зөвшөөрсөн” гэсэн өргөдөл бүрийг сонгож тус бүр дээр нь тайлан үүсгэнэ.

5.4.“Өөрчлөх” гэсэн цонхыг сонгож, импортолсон болон борлуулсан тоо, үнийн дүнг оруулна.

5.5.“Зөвшөөрөх” гэсэн цонхыг сонгосноор тайлан ЭМХТ-нд илгээгдэнэ.